



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2017 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.4.6, 13.4.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/33 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Үндэсний аудитын газрын, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл”-ийн “Нэг. Удирдлагын зөвлөл” бүлгийн дээрээсээ 2 дахь догол мөрийн “Санхүүгийн аудитын газрын захирал” гэсний дараа “Бодлого, төлөвлөлтийн газрын захирал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга” гэж нэмсүгэй.

2. Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/33 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Үндэсний аудитын газрын, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл”, гуравдугаар хавсралтаар батлагдсан “Үндэсний аудитын газрын орон тоо, албан тушаалын жагсаалт”-д дор дурдсан өөрчлөлтийг тус тус оруулсугай.

1/ тушаалын 2 дугаар хавсралтын “Зургаа. Ерөнхий аудиторов төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудыг хариуцсан орлогч бөгөөд тэргүүлэх аудитор” бүлгийн “Ажлын албаны эрхлэх асуудлын тухайд” хэсгийн дээрээсээ 2 дахь заалт “Төрийн аудитын байгууллагын төсвийг төлөвлөх, төсвийн хязгаарын санал боловсруулах, төсвийн төслийн санал бэлтгэх” гэснийг “Төрийн аудитын байгууллагын төсвийг төлөвлөх, аудитын зардлыг тооцоолох, төсвийн төслийн санал бэлтгэх” гэж, мөн хэсгийн дээрээсээ 16 дахь заалт “... мониторинг, дүн шинжилгээ...” гэснийг “системчилсэн үнэлгээ” гэж;

2/ тушаалын 2 дугаар хавсралтын “Ес. Аудитын зөвлөл” бүлгийн 4 дэх заалт “Аудитын зөвлөл нь төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагуудаас хийх аудитын хуваарь, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөв, зардлыг хэлэлцэхээс гадна аудитын гүйцэтгэл, чанар, үр дүн, үр нөлөө, холбогдох бусад асуудлыг хэлэлцэж, сайжруулах зөвлөмж өгч, санал боловсруулна.” гэснийг “Аудитын зөвлөл нь төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагуудаас хийх аудитын хуваарь, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөв, зардал, түүний хэрэгжилт, гүйцэтгэл болон тайлан, үр дүн, үр нөлөө, холбогдох бусад асуудлыг хэлэлцэж, сайжруулах зөвлөмж өгч, санал боловсруулна.” гэж;

3/ тушаалын 3 дугаар хавсралт болох жагсаалтын 11 дугаартай мөрийн хоёр дахь баганад байх “Ерөнхий нягтлан бодогч, Эдийн засагч” гэснийг “Ерөнхий санхүүч” гэж;

4/ тушаалын 3 дугаар хавсралт болох жагсаалтын 14 дугаартай мөрийн хоёр дахь баганад байх “Нягтлан бодогч” гэснийг “Эдийн засагч, нягтлан бодогч” гэж;

5/ тушаалын 3 дугаар хавсралт болох жагсаалтын 24 дугаартай мөрийн хоёр дахь баганад байх “Худалдан авалт хариуцсан мэргэжилтэн” гэснийг “Эд хариуцагч бөгөөд худалдан авалт хариуцсан мэргэжилтэн” гэж;

6/ тушаалын 3 дугаар хавсралт болох жагсаалтын 26 дугаартай мөрийн хоёр дахь баганад байх “Эд хариуцагч бөгөөд архивын ажилтан” гэснийг “Архивын ажилтан” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

3. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/33 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Үндэсний аудитын газрын, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл”-ийн “Зургаа. Ерөнхий аудиторын төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудыг хариуцсан орлогч бөгөөд тэргүүлэх аудитор” бүлгийн “Ажлын албаны эрхлэх асуудлын тухайд” хэсгийн дээрээсээ 11 дэх заалт “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагын ажилтны нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах”-ийг хасах.

4. Энэхүү тушаалаар орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох баримт бичигт зохих журмын дагуу тусгаж, албан хаагчдад танилцуулахыг Тамгын газар /Ц.Ганболд/-т даалгасугай.

5. Энэхүү тушаалыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР